



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

135 /135/

2021.09.15

ҮЙЛ ЯВДАЛ

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫНХАН ХУВИЙН АВТОМАШИНААС ТАТГАЛЗЛАА

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн уриалгыг дэмжиж, Монгол Улсын Засгийн газар, Нийслэлээс хэрэгжүүлж буй автозамын ачааллыг бууруулах бодлогын хүрээнд Батлан хамгаалах яам, түүний харьяа төсөвт болон төрийн өмчит байгууллагууд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, ангиудын алба хаагчид хувийн автомашиныг ажлын цагаар хэрэглэхгүй байх тухай Батлан хамгаалахын сайдын тушаал гарлаа. Тушаалын дагуу өнөөдрөөс эхлэн Батлан хамгаалах салбарын алба хаагчдын



БУСАД САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД ДЭМЖЭЭСЭЙ

Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын инженер Г.ДАШЖАМЦ:
-Хувийн машинаараа ажилдаа ирж очдог. Өнөөдөр нийтийн тээвэрээр үйлчлүүлээ. Бусад салбарын алба хаагчид бас ийм санаачилга гаргавал замын түгжрэл арилах төдийгүй эдийн засгийн хувьд ч хэмнэлт гарах байх. Миний хувьд хүндрэлтэй зүйл алга, ажлаасаа хол гэртэй хүмүүсийн хувьд асуудалтай байж магадгүй. Тийм учраас. нийтийн тээврийнхээ тоог нэмж явуулбал зүгээр байх.

ЦЭРГИЙНХНИЙ ШИЙДВЭРТ ТАЛАРХАЖ БАЙНА

Иргэн С.ДҮҮРЭНБАЯР:
-Цэргийнхэн ийм шийдвэр гаргасныг та нараас дуулж байна. Даанч энэ хавийн зогсоол цэлийгээд байсан юм. Төрийн хувийн гэлтгүй бүх байгууллага, хүмүүс ийм шийдвэр гарган дагаж мөрдвөл замын түгжээ зохих хэмжээгээр багасах байх. Би өглөө бүр ачаа цэцэрлэгт хүргэж өгдөг. Офицеруудын ордны орчим замын хөдөлгөөн үнэхээр ихтэй. Сургууль, цэцэрлэг их байдаг болоод ч тэр үү бум бужигнадаг газар. Цэргийнхэндээ үнэхээр их талархаж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ХЭМНЭЛТТЭЙ, ЭРҮҮЛ МЭНДЭД ТУСТАЙ

ЦДБЭЧ-ын бүжигчин, ахлах ахлагч Б.БОЛДБААТАР:
-Өнөөдөр дугуй унаж ажилдаа ирлээ. Эдийн засгийн хэмнэлттэй, дээр нь эрүүл мэндэд тустай. Ийм шийдвэр гараагүй бол залуураад хэдэн буудлын хооронд машинаа унаад л явах байсан биз. Өдөрт бараг 10000 төгрөгийн түлш зарцуулдаг. Замын түгжрэлийг бууруулахад хувь нэмрээ оруулж байгаа гэж бодохоор баяртай байна.



2161 автомашин замын хөдөлгөөнд оролцохгүй бөгөөд тусгай үйлчилгээний автобусаар алба хаагчдын тээвэрлэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах үүрэг, чиглэлийг харьяа байгууллагуудын удирдлагуудад өгсөн юм. Мөн албан хэргэнд ашиглагдаж буй албан ажлын болон дуудлагын автомашины тоог 60 хувиар буурууллаа. Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулахад хувь нэмрээ оруулах нь Батлан хамгаалах салбарын алба хаагчдын үүрэг гэж үзэн ийнхүү шийдвэрлэжээ. Энэхүү санаачилгыг бусад төрийн албан хаагчид дэмжиж, хувийн автомашинаас татгалзахыг Батлан хамгаалах салбарынхан уриалж байна. Бид зарим алба хаагчдын сэтгэгдлийг хуваалцлаа.

ЭЛЧИН САЙД КЭТРИН ЭЛАЗАБЕТ ИВКОФЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр 2021 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Кэтрин Элизабет Ивкофыг хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд Канад Улсад зохион байгуулагддаг англи, франц хэлний урт хугацааны дамжаа, англи хэлний багшийн дамжаа, энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр богино хугацааны сургалт, дамжаануудад суралцах боломж олгон цэргийн алба хаагчдын сургалт, боловсролын чиглэлээр хамтран ажиллаж ирсэн Канад Улсын засгийн газарт талархаж байгаагаа илэрхийлэв.

хүчний сургагч багш нарыг Монгол Улсад жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Хааны Эрэлд" олон улсын сургуульд урьж оролцуулдагт Батлан хамгаалахын сайдад хариу талархал илэрхийлэв.

Уулзалтаар хоёр улсын харилцаа, тэр дундаа Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиглэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар болон Афганистан Улсад үүсээд буй нөхцөл байдал, бүс нутгийн аюулгүй байдлын талаар харилцан санал солилцлоо. Уулзалтын төгсгөлд талууд хоёр улсын тогтоосон хамтын ажиллагаа олон жилийн турш тасралтгүй хөгжиж ирсэнд баяртай байгаагаа илэрхийлэн, цаашид хоёр улсын Батлан хамгаалах салбарын харилцаа, тэр дундаа цэргийн боловсролын чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлж, илүү олон чиглэлд хамтарч ажиллахаа мэдэгдлээ.

Элчин сайд хатагтай Кэтрин Элизабет Ивкоф Бээжин хотоос Монгол Улсыг хавсран суугаа Канад Улсын цэргийн атташе болон Канадын Зэвсэгт

ЦЭРГИЙН ЧУУЛГЫН АХМАДУУД ЭНГЭРЭЭ МЯЛААЛГАЛАА



Монгол Улсад Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны яруу алдарт 100 жил, Орчин цагийн соёл урлагийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ой энэ онд тохиож байна.

Энэхүү баярт мөчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Цэргийн гавьяаны одонгоор ЦДБЭЧ-ын ахмад бүжигчин, МУСТА Ц.Энхдаваа, Хөдөлмөрийн хүндэт медалиар ахмад бүжигчин Л.Мөнгөнчимэг, "Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан" цол тэмдгээр ЦДБЭЧ-ын ахмад бүжигчин Ц.Ганбаяр нар шагнагдсаныг чуулгын

удирдлага гардуулж баяр хүргэлээ.

Мөн өнгөрөгч долоо хоногт ЦДБЭЧ-ын ахмад ажилтнуудаас гэрэлтүүлэгч Б.Оюундэлгэр, үйлчлэгч Г.Даваажав нар "Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан" цол тэмдгээр, үйлчлэгч П.Цэцэгмаа Монгол Улсын Соёлын яамны "Жуух бичиг"-ээр тус тус шагнагдсан билээ.

Монгол цэргийн яруу алдрыг бүжихүйн урлагаар мөнхлөн дархлагч ахмад бүжигчдэдээ болон арын албаны арвин үйлст ажилтан албан хаагчдааа гэгээн сайхны ерөөлийг өргөж, урт нас удаан жаргалыг хүсье!

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 254,605 +2939	ЭДГЭРСЭН 243,898 +4825	НАС БАРСАН 1022 +10
-----------------------------------	---------------------------	------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4911 +83	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 195	ЭДГЭРСЭН 4623
-----------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 223,368,662
Эдгэрсэн Нийт: 199,873,841
Нас барсан Нийт: 4,608,597

Түүхэнд энэ өдөр

1939 он:

Москвад болсон хэлэлцээрийн дагуу Халхын голын районд хоёр тал байлдааны ажиллагааг зогсоохоор болжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
16	1

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
33	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.00	2,855.00
EUR	3,335.0	3,388.0
CNY	440.0	444.40
RUB	38.50	40.20
JPY	25.70	26.19
KRW	2.35	2.47

ЗУРХАЙ

2021.09.15 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 9/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН ХОЁР ХАР УЛААН БАР ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин өчүүхэн ирнэ

Наран ургах, шингих:

06.29-19.06

Барилдлага:

Рашаан

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Суудал:

Төмөр

Арвын тооллын 9 дүгээр сарын 15, Буд гараг. Билгийн тооллын 9, Суулга одтой, улаан бар өдөр. Өдрийн наран 06 цаг 29 минутад мандан, 19 цаг 06 минутад жаргана. Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг могой нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамырыг сэрээх, хараал, жатхыг буцаах, амлуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, андгай тангараг, гэрээ хэлцээ буцахад сайн. Золиг гаргах, бомбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой.

Үс шинээр үргээлгээ буюу засуулахад тохиромжгүй.

Үйл явдал

Т.Ганбат: БИДНИЙ АЖЛЫН ГОЛ ЗОРИЛГО НЬ ОФИЦЕРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ЧАДВАРЖУУЛАХ

Ерөнхийлөгчийн цэргийн байгууллагын референт Т.ГАНБАТ

Тамгын газрын Төрийн асуудал хариуцсан ахлах

Сүүлийн үед цэрэг, цагдаагийн байгууллагуудад цэргийн цолны зохицой харьцаа алдагдаж, түүний дотор ахлах офицеруудын эзлэх хувь нийт офицеруудын тоотой харьцуулахад өндөр, түүнчлэн офицерын цолны зэрэг дэвийн шаардлага хангаагүй, цэргийн зохицой ёсны боловсрол эзэмшээгүй, цэргийн алба хаагаагүй, офицерын албанд элсүүлэх насны дээд хязгаар хэтэрсэн иргэд, спорт, урлагийнханд цэргийн цолыг хавтгайруулан олгож байгаа зэрэгт иргэд, олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байгаа билээ. Энэ нь мэргэжлийн армийн ноён нуруу болсон офицерын бүрэлдэхүүний алба хаах хүсэл зориг, итгэл үнэмшлийг бууруулж байгаа талаар ч мэргэжлийнхэн өгүүлж байна.

Иймд дээрх гажуудлыг засаж залруулах, холбогдох хууль эрх зүйн баримт бичгүүдэд өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг хангах чиглэлээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн захиралжаар "Цэргийн цол олгох журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Бид энэ талаар тус ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Төрийн цэргийн байгууллагын асуудал хариуцсан ахлах референт Т.Ганбаттай уулзаж тодруулга авлаа.

Генерал цолыг хавтгайруулан олгодоо, цолондоо олширлоо гэх олон нийтийн бухимдал дунд "Цэргийн цол олгох журам"-ыг шинэчлэн боловсруулах ажил эхэллээ. Ажлын хэсгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгнө үү?

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 38 тоот захирамжаар "Цэргийн цол олгох журам", "Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл"-ийг шинэчлэн батлуулах ажлын хэсгийг байгуулж, даргаар нь Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, орлогч даргаар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо нарыг томилж, бүрэлдэхүүнд нь Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Батлан хамгаалах яам, Хууль зүй дотоод хэргийн яам болон Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдах албан тушаалтнууд томилогдон ажиллаж байна. Бид анхны хуралдаанаа 8 дугаар сарын 18-нд, хоёр дахь хуралдаанаа 9 дүгээр сарын 3-ны өдөр зохион байгуулсан. Хоёрдугаар хуралдаанаар энэ асуудлыг ул суурьтай судалж үзэх шаардлагатай гэж үзээд, гурван ажлын дэд хэсэг байгуулж, холбогдох судалгаа шинжилгээний ажил хийгээд байна. Есдүгээр сарын 8-ны өдөр гуравдугаар хуралдаанаараа дээрх ажлын хэсгүүдийн тайланг авч хэлэлцлээ.

Та хоёрдугаар хуралдаанаа сэдэв ахлын хэсгүүдийн үйл ажиллагааны чиглэл, тэдгээрийн ажлын үр дүнгийн талаар тодруулна уу.

-Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдад цэргийн цол олгосон өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх ажлын хэсэг, "Цэргийн цол олгох журам"-д өөрчлөлт оруулах бодлого чиглэлийг боловсруулах, үүнийг дагаж гарах хууль эрх зүйн баримт бичгүүдэд өөрчлөлт оруулах бодлогыг тодорхойлох ажлын хэсэг, мөн "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм"-ийн хэрэгжилтийн хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг судлах чиглэлээр ажилласан ажлын хэсгүүд маань тус бүр судалгаа, тайлангаа тавьж, санал бодлоо солилцож, хэлэлцүүлэг өрнүүлээ. Одоо ажлын хэсгүүдийн ажлын үр дүн, санал дүгнэлтийг нэгтгэж нарийвчлан боловсруулаад холбогдох шийдвэрийн эцсийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьж, баталгаажуулахаар ажиллаж байна.

Энэхүү журмыг шинэчлэн батлах гол зорилго нь юу вэ?

-Монголын Зэвсэгт хүчин мэргэжлийн цэрэгт суурилсан мэргэшсэн Зэвсэгт хүчин болох зорилт тавин ажиллаж байгаа. Мэргэжлийн Зэвсэгт хүчний гол ноён нуруу нь офицерууд гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Бидний ажлын гол зорилго нь офицерын бүрэлдэхүүнийг чадавхжуулах явдал юм. Ингэхийн тулд бид офицерын цолонд тавигдах шаардлагыг өндөржүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, дунд офицер ахлах офицер болохын тулд цэргийн академи төгссөн байх, хошууч цолтой хүн дэд хурандаа болохын тулд мэргэжлээрээ магистрын зэрэг хамгаалсан байх, дэд хурандаа хүн хурандаа болохын тулд аль нэг энгийн мэргэжлээр мастерын зэрэг хамгаалсан байх гэдэг ч юм уу нэг цолноос нөгөө цол руу шилжихэд мэргэжил, боловсролд тавигдах шалгуур үзүүлэлтийг тодорхойлох юм. Цэргийн цол нь цэргийн алба хаагчийн эрхэлж байгаа албан тушаалын ангиллын илэрхийлэл, түүнийг цэргийн боловсрол, цэргийн жинхэнэ алба хаасан хугацаанд харгалзуулсан зэрэг дэв юм. Тиймээс тухайн албан тушаалд томилогдож байгаа хүн өөрөө чадавхтай байж, тухайн цолныхоо эзэн болох учиртай. Ингэснээр цэргийн албаны нэр хүнд өсөж, цэргийн алба хаагчдын алба хаах итгэл үнэмшил дээшилнэ гэж бид үзэж

байгаа. Цолны асуудлыг ингэж зөвхөн мэргэжил, боловсролтой нь холбоод зогсохгүй бид цаашдаа ажлын хэсэг байгуулж, цэргийн алба хаагчдын бие бялдрын стандартыг гаргаж мөрдүүлэх талаар анхаарч, нэлээд арга хэмжээ зохион байгуулна. Тухайлбал, цэргийнхэн өглөө эрт босож,

хэрэглэх хэрэгтэй юм бол заавал Зэвсэгт хүчинтэй адилхан байх уу, өөр өнгө загвартай байх уу гэдгийг бодолцох ёстой болж байгааг цаг үе харуулж байна.

"Цэргийн цол олгох журам"-д орж буй томоохон өөрчлөлтүүдээс дурдаж болох уу.

-Цэргийн цолны

дүрэм хэрэгжих хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна гэж харж байна. Тухайлбал, "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм"-д "Цэргийн дүрэмт хувцсыг хууль бусаар үйлдвэрлэх, худалдах, бусдад шилжүүлэх зэрэгт Зөрчлийн хуулиар арга хэмжээ авна" гээд заачихсан байдаг. Гэтэл хуулийн энэ заалт биелдэггүй,

хувцасны хууль бус худалдааг цэцэглүүлж байна гэж үзэж байгаа. Цэргийн хувцсыг хатуу норм тогтоогоод олгоод байхаар зарим тохиолдолд эдэлгээний хугацаа дуусаагүй хувцсаа ах дүүс, найз нөхдөдөө шилжүүлэх байдлаар дүрэмт хувцасны зүй зохисгүй, замбараагүй хэрэглээг бий болгож байна. Иймд алба хаагчид өөрсдөө мөнгөөрөө хувцас худалдан авах болсноор ариг гамтай өмсөж эдлэхээс гадна төсвийн хэмнэлт үүснэ, бас бусдад шилжүүлдэг явдал багасна.

Цэргийн хувцас өмсөх асуудал эргээд "Цэргийн цол олгох журам"-тайгаа уялдана. Дайчилгааны тухай хуульд Дайчилгааны бэлтгэл сургуулиалт, стратегийн цугларалт, дадлагад оролцсон бүрэлдэхүүнд бэлтгэл офицерын цол олгоно гэж заасан байдаг. Тамгын газрын удирдах албан тушаалын ажилтнуудтай 3 хоногийн цугларалт хийж, бэлтгэл офицерын цол олгон, цэргийн хувцас хэрэглэл өгдөг. Тэд хувцсаа ажлын хувцас мэт гамшиг осол, нийтийн цэвэрлэгээ үйлчилгээ, аялал зугаалга, ан гөрөөнд явах зэрэгтээ өмсчихдөг. Энэ бол байж болохгүй асуудал. Зөвхөн дайчилгааны бэлтгэл, сургуулиалт оролцсон, оногдуулан данслагдсан албан бэлтгэл үүрэгтнүүдэд цэргийн цолыг олгож болно, гэхдээ цэргийн цол, хувцсыг зөвхөн тэр арга хэмжээнд оролцохдоо л хэрэглэнэ, бусад үед хэрэглэхийг хориглох шаардлагатай байгаа. Үүнийг дагаад цэргийн хувцсыг хэн дуртай нь өмсөх гарц хаагдана гэж бид бодож байна.

Тэгэхээр зөвхөн "Цэргийн цол олгох журам", "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм" өөрчлөгдөн шинэчлэгдээд зогсохгүй үүнийг дагасан хууль, эрх зүйн зохицуулалт хийгдэх нь ээ.

-Тийм ээ, "Цэргийн цол олгох журам"-ыг өөрчлөхтэй холбоотойгоор дагаж хийгдэх хууль эрх зүйн баримт бичгүүдэд орох өөрчлөлтийг бид бас судалж байгаа. Тухайлбал, Цэргийн албаны тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль дахь цэргийн цолны талаарх заалтуудыг эргэн харах шаардлагатай болж байна. "Цол олгох журам"-ыг өөрчлөн шинэчилсний дараа хууль эрх зүйн баримт бичгүүдийн шинэчлэлт, өөрчлөлтийн ажлууд шат дараалан хийгдэнэ.

"Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл", "Цэргийн цол олгох журам" шинэчлэгдсэнээр өнөөдөр нэгэн цолоо авчигдсан, албан тушаал эрхэлж байгаа нэлээд хүмүүсийн эрх ашиг хөндөгдөх л байх даа.

-Мэдээж, энэхүү дүрэм батлагдсанаар нэг хэсэг бужигнаа. Дургүй хүмүүс гарч л таараа, гэхдээ сайшааж хүлээж авах нь түүнээс хавьгүй олон гэж найдаж байна.

Д.ГҮНЖИЛМАА



олны дунд гүйдэг, биеийн тамираар хичээллэдэг, долоо хоног бүр спортын уралдаан тэмцээн зохион байгуулдаг, олон нийтийг уриалдаг, манлайлдаг байх ёстой гэж үзэж байгаа. Ялангуяа, ахлах, дээд цолтой офицерууд бие бялдраараа бусдыгаа үлгэрлэдэг байх ёстой.

Журамд өөрчлөлт оруулж, шинэчлэхийн тулд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдад цэргийн цол олгосон өнөөгийн байдал судалгаа шинжилгээ нэлээд хийсэн байх.

-Энэхүү журмыг шинэчлэхийн тулд судалгааны ажил их хийгдсэн. Цэргийн цолыг баяр ёслолыг тохиолдуулан шагналын журмаар гардуулах, хугацаанаас өмнө олгох, цэргийн ямар ч боловсролгүй хүмүүс цэргийн цол авах, улс төрийн томилгоогоор энгийн хүн цэргийн албан тушаал хашиж, цол хүртэх, урлаг, спортын амжилт гаргасан иргэдэд хавтгайруулан олгох зэрэг цэргийн цолтой холбоотой зөрчил дутагдал, зүй зохисгүй байдлууд судалгаагаар тогтоогдсон. Мөн цэргийн дүрэмт хувцас өмсөхтэй холбоотой асуудлууд нэлээд гарсан. Батлан хамгаалах тухай хуулиар Төрийн цэргийн байгууллагуудад Зэвсэгт хүчин, Хил болон Дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллага багтдаг. Гэтэл өнөөдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Тагнуул, Төрийн тусгай хамгаалалт зэрэг хууль сахиулах бусад байгууллагын тухай хуульд алба хаагчид нь цэрэг хувцастай байна, цэргийн цол хэрэглэнэ гээд заачихсан байдаг. Төрийн цэргийн байгууллагын доторх тогтолцоог өөрчлөх бус хууль сахиулах байгууллагууд маань цэргийн хувцас

хугацаанд өөрчлөлт орж байгаа. Тухайлбал, ахмадаас хошууч хүртэл цол хоорондын зай 4 жил байсан. Бид +2 гэсэн заалт оруулж байгаа. Хүн ахмад цолтой 4 жил болоод хошууч болж чадаагүй бол ахмад 2 жил өгнө. Зургаан жилийн дотор хошууч цолоо авч чадахгүй бол тэтгэвэрт нь гаргах асуудлыг судалж байгаа. Гэхдээ тэтгэвэр чөлөөнд гаргахдаа нэг удаагийн тэтгэмж өндөр байх, мөн энгийн амьдралд хөл тавих мэргэжил боловсролын асуудалд дэмжлэг үзүүлэх зэргээр хувь хүнийг хохироохгүй байх асуудлыг ч бодолцож байгаа. Цэргийн цолыг төсөвтэй уялдуулах гарцыг бид бас судалж байна. Өөрөөр хэлбэл, шаардлагатай албан тушаалын цолны тоог тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсөвтэйгөө уялдуулж, жил бүр тогтоож байх ёстой. Түүнээс хэтрүүлэн олгож болохгүй. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын цолны зэрэглэл, ангиллыг Хууль зүй, дотоод хэргийн сайд тогтоож байх жишээтэй. Өнөөгийн байдлаар цэргийн цолны ангилал, зэрэглэл төсөвтэй хамаарах уялдаа алдагдсан байна. Тэрчлэн хугацаанаас нь өмнө цол олгох, бүр авах ёсгүй хүнд өгдөг, албан тушаалын зэрэглэл буусан ч хуучин цолтойгоо ажиллах зүй бус байдлуудыг цэгцлэх зорилготой ажиллаж байна.

Өнөөгийн мөрдөгдөж байгаа "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм"-д бас өөрчлөлт орох уу?

-Энэ оны 4 дүгээр сарын 12-нд ЗХЖШ-ын даргын тушаалаар батлагдсан "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм" нь нэг их гар хүрээд байхааргүй чамбай дүрэм. Гэхдээ энэ

хэрэгжүүлэх, хянах субъект нь тодорхойгүй. Цэргийн цагдаа гээд заачихсан хэр нь тэр алба нь ялангуяа аймаг, орон нутагт өнөө хүртэл байгуулагдаагүй. Зөрчлийн хуулийг хянах байгууллага нь цагдаа. Цагдаад цэргийн хувцасны зөрчлийн талаарх мэдээлэл, дуудлага хэзээ ч очдоггүй. Тэгэхээр цагдаа нь энэ манай ажил биш гэдэг. Зөрчлийн хуульд заагдсан заалтуудыг албан ёсоор Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлж, албан ёсоор баталгаажуулдаг бололтой. Түүний дараа түүнийг хэрэгжүүлэх, хянах субъектүүдийг тодорхой болгодог. "Цэргийн дүрэмт хувцсыг бусдад зарах юм бол байлдааны зэвсгээ зарсантай адил тооцно" гээд Цэргийн дүрэмдээ заачихсан байгаа. Гэтэл хэрэгжүүлэх байгууллага нь тодорхойгүй учир хэрэгждэггүй.

Цэргийн хувцастай холбоотой хэд хэдэн дорвитой өөрчлөлтүүд орно. Цэргийн ангид ажиллаж байгаа бие бүрэлдэхүүний эрэн хувцасны норм богино, албаны ногоон хувцасны норм урт байх, удирдах байгууллагад ажиллаж байгаа алба хаагчдын албаны хувцасны хугацаа урт, эрэн хувцасны хугацаа богино байх, мөн цэргийн хувцсыг нэг удаа үнэгүй олгоод, дараа нь алба хаагч өөрөө мөнгөөрөө худалдаж авах, тэтгэвэр, чөлөөнд гарч буй хүмүүсийн хувцасны хэрэглээг цэгцлэх, цэргийн хувцасны хууль бус худалдааг таслан зогсоох зэргийг бид судалж байна.

Анги, салбарт ажиллаж байгаа цэргийн алба хаагчдын хувцас хангалтын хугацаандаа хүрэлгүй элэгддэг, өнгө зүс алддаг, дараагийн хангалтыг хүлээх аргагүй болж хувь хүн, аж ахуйн нэгжээс хувцсаа худалдан авч, цэргийн